

# ХЭЛ ЗОХИОЛ


Бүгд Найрамдах Монгол Ард Улсын  
Шинжлэх Ухаан, Дээд Боловсролын Хүрээлэнгийн  
Хэл Зохиол Судлах Газрын цуврал бичиг  
Тэргүүн боть Дэд дэвтэр

Лувсандэндэв (Улаанбаатар)

|                           |
|---------------------------|
| А У<br>000411<br>00516(8) |
|---------------------------|

к

## Монгол үгийн бүтэц



Ринчен д-р. проф, найруулан засав

Эрдэм Шинжилгээний  
хэвлэх үйлдвэр.

Улаанбаатар

1960

# ХЭЛ БИЧИГ

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Шинжлэх  
Ухаан, Дээд Боловсролын Хүрээлэнгийн Хэл  
Зохиол Судлах газрын цуврал бичиг

Найруулан засагч. Эрдэм шинжилгээний ахлах  
ажилтан Лувсандэндэв, Ринченсамбуу

## Лувсандэндэв

### МОНГОЛ ҮГИЙН БҮТЭЦ

Алива хэлэнд үгс байдаг. Үгс нь дангаараа хэл болж чадахгүй боловч хэлийг бүтээдэг хэрэглэгдэхүүн юм. Байшин барихад тоосго, мод, чулуу нь дангаараа барилгыг бүтээдэггүй, тэдгээрийг барилгын ухааны ёсоор нарийн журам горимтой өрж, бэхлэж, шавж хийсээр сая байшинтай болдгийн адил, хэлний барилгын хэрэглэгдэхүүн болох үгсийг дүрэм горимтой хэрэглэж хэл бүтдэг. Тэр дүрэм горимы нь хэлзүй гэдэг. Барилгын ухааны ёсоор байшин босгохын тул, шавраар тоосго хийх, мод хөрөөдөж харуулдах, чулуу хагалж, зүсэж өнгөлөх зэргээр барилгын хэрэглэгдэхүүнийг боловсруулсан байх хэрэгтэй. Ингэж боловсруулахын тул, уул хэрэглэгдэхүүний чанарыг мэдэх хэрэгтэй. Үүнчлэн хэлний барилгын хэрэглэгдэхүүн болох үгсийг хэлзүй ёсоор боловсруулан ашиглахын тул, тэдгээрийн шинж тэмдэг, чанарыг, өөрөөр хэлбэл бүтций нь мэдэх хэрэгтэй.

#### БҮТЭЭВЭР

Үгсийн бүтэцтэй танилцахын тул сурга гэсэн үгийг аваад задлаж үзье. Үүнд энэ үгийг хоёр янзаар хэсэглэн хувиаж болох байна. Нэгд: с-у-р-г-а гэж таван хэсэг болгон задлаж болно. Энэ бол авианзүйн арга юм. Ингэж хувиахад үг нь тус тус авиа болон задарч байна. Хоёрт: сур-га гэж хоёр хэсэг болгон хувиаж болох байна. Энэ нь үгзүйн арга юм. Энэ аргыг хэрэглэхэд, үг нь утга бүхий хэсэг, бүтээвэр болон задарч байна. Энэ хоёр арга, өөр өөр болох нь, үзэхүйц илхэн байна. Авиа бол, дангаараа ямар ч утгагүй, утга агуулгатай шууд холбоогүй зүйл юм. Үнэхээр с авиа ямар утгатай вэ?, у авиа ямар утгатай вэ? гэх зэрэг асуулт тавивал ямар ч утгагүй болохы нь харуулна.

Ийнхүү авиа дангаараа үгийн утгад хамаагүй байна. Гэтэл бүхэл үгийн утга, түүний бүрэлдэхүүнд орсон авиа бүрд шууд хамаатай байна. Сурга гэсэн үгийн с авиаг хасах буюу ямар нэг авиагаар соливол, утга нь өөр болох буюу эсэхүл уул үг эвдэрч ямар ч утгагүй хэдэн авианы цогц болно.

Харин, бүтээвэр бол үгийн утгатай шууд холбоотой, өөрөөр хэлбэл, үгийн утга бүхий хэсэг нь юм.

Ийнхүү, үгс нь зөвхөн авиа болон задрах бус, мөн бүтээвэр болон задрах аж.

Бүтээвэр гэгч нь үгийн утга бүхий хамгийн бага нэгж юм. Хамгийн бага гэж онцлон хэлдгийн учир юу вэ? гэвэл: сургуул

гэсэн үгийг сург(а)—уул гэж задлаж болох юм. Гэтэл сурга— гэдэг нь сургуул гэсэн үгийн утга бүхий хэсэг мөн боловч бүтээвэр болохгүй, яагаад гэвэл өөрөө цааш задран утга бүхий хэсэг болон хувиагдаж байна.

Бүтээвэр бол, үгийн нэг хэсэг нь юм. Гэвч, бүтээвэр бүхэн харилцан адилгүй. Чанарын талаар хэдэн янз бүтээвэр байдаг.

### Язгуур

Хэсэг үгийг аваад, дээр дурдсан үгзүйн аргаар задлан үзье.

Мал- чи-н, мал-ла-х, мал-жи-х

Ул- аа-н, ул- ай-х, ул-аа-гана

гүй- дэл, гүй-гч, гүй-х

Эдгээр үгийн бүтээврүүдийг адгаас нь хасахад, эцэст нь цааш задрахгүй бүтээвэр үлдэж байгаа нь язгуур бүтээвэр юм. Язгуур, үгийн дотор бүхэлд нь гүйцэтгэж байгаа үүргээрээ, үгийн утгад бүхэлд нь ямар хамаатайгаараа бусад бүтээврээс ялгаатай байна.

Нэг талаар, язгуур бол чухам ямар бодис, тэмдэг, үйлийг бүтэн үгээр нэрлэснийг харуулдаг. Хэрэв бүтэн үг нь (малчин гэх мэтчилэн) бодисыг нэрлэсэн бол, язгуур бүтээвэр нь (мал- гэх мэтчилэн) чухам ямар бодис болохыг, хэрэв бүтэн үг нь (улаан гэх мэтчилэн) тэмдгийг заасан бол, язгуур нь (ул- гэх мэтчилэн) чухам ямар тэмдэг болохыг, хэрэв бүтэн үг нь (гүйх гэх мэтчилэн) үйлийг илтгэсэн бол, язгуур нь (гүй- гэх мэтчилэн) чухам ямар үйл болохыг зааж байна.

Нөгөө талаас, язгуур бүтээвэр нь бодис, тэмдэг, үйлийг хэрхэн яаж нэрлэснийг заадаг. Хэрэв бүтэн үг нь (улаагана, гүйдэл, малчин гэх мэтчилэн) бодисыг нэрлэж байвал, язгуур нь (ул- гэх мэтчилэн) хамгийн гол шинж тэмдгээр нь, (гүй-гэх мэтчилэн) хамгийн гол үйлээр нь (мал- гэх мэтчилэн) өөр бодистой ямар харьцаатай байгаагаар нь нэрлэснийг тус тус харуулж байна.

Ийнхүү, үгийн язгуур гэдэг нь, тухайн үг ямар бодис, тэмдэг, үйлийг зааж буй буюу тухайн бодис, тэмдэг, үйлийг хэрхэн яаж нэрлэж байгааг үзүүлдэг үгийн эхний цааш задрахгүй бүтээвэр мөн байна.

Аливаа язгуур нь хоёроос доошгүй үгэнд тохиолдоно. Зарим язгуур нилээд олон үгэнд тохиолдоно. Жишээлбэл, ца-язгуур цаас (ᠴᠠᠰ), цагаалж (ᠴᠠᠭᠠᠯᠵ), цагаадах (ᠴᠠᠭᠠᠳᠠᠬ), цагаарах (ᠴᠠᠭᠠᠶᠠᠷᠠᠬ), цагаач (ᠴᠠᠭᠠᠭᠴ), цайвар (ᠴᠠᠶᠢᠪᠠᠷ), цагаалах (ᠴᠠᠭᠠᠯᠠᠬ), цавь (ᠴᠠᠪᠢ), цайх (ᠴᠠᠶᠢᠬ), цас (ᠴᠠᠰ), цагаан (ᠴᠠᠭᠠᠨ), цайвгар (ᠴᠠᠶᠢᠪᠭᠠᠷ), цайрах (ᠴᠠᠶᠢᠷᠠᠬ), цайвалзал (ᠴᠠᠶᠢᠪᠠᠯᠵᠠᠯ), цайр (ᠴᠠᠶᠢᠷ), цас (ᠴᠠᠰ), цалбуурал (ᠴᠠᠯᠪᠤᠭᠤᠷᠠᠯ), цахир (ᠴᠠᠬᠢᠷ), цахилгаан (ᠴᠠᠬᠢᠯᠭᠠᠨ) гэх мэт үгэнд байна. Ийм үгийг нэгэн язгуурт үгс гэдэг.

Язгуур нь, хэл хэлэнд янз янзын авианзүйн онцлогтой байдаг.<sup>1</sup> Жишээлбэл, монгол язгуур нь хэлний хойгуур үгүүлэгдэх и, мөн р авиа, хоёр гийгүүлэгчээр эхлэдэггүй, гол төлөв ганц үеэр бүтдэг, чин

<sup>1</sup> Солонгос хэлэнд үгийн язгуур сонсголонт гийгүүлэгч, хоёр гийгүүлэгчээр эхлэдэггүй. Япон хэлэнд бодисын нэрийн язгуур анирт гийгүүлэгчээр төгсдөггүй. Хаятад хэлэнд язгуур анирт гийгүүлэгчээр төгсдөггүй.

гэхдээ дан эгшиг, эгшиг гийгүүлэгч, гийгүүлэгч эгшиг, гийгүүлэгч эгшиг гийгүүлэгч гэсэн ийм дөрвөн янз үеэр бүтдэг. Үүнд эгшигийг Э, гийгүүлэгчийг Г гэж товчилбол дор дурдсан томьёолол хийж болно.

томьёолол: жишээ:

|     |         |         |            |            |
|-----|---------|---------|------------|------------|
| Э   | оо, өө, | ий,     | а-хуй      |            |
| ЭГ  | он үүр, | (цайх), | ав, өс-вөр |            |
| ГЭ  | тэр,    | гэ-,    | хий-,      | я-с (й-са) |
| ГЭГ | гар,    | гал,    | хэв,       | бол-гоомж  |

Зарим эрдэмтэн монгол, турк, манж буюу өөрөөр хэлбэл алтай язгуурын хэлэнд хоёр үеэр бүтсэн үгийн язгуур байдаг бөгөөд гийгүүлэгч эгшиг гийгүүлэгч эгшиг, эгшиг гийгүүлэгч гийгүүлэгч эгшиг, эгшиг гийгүүлэгч эгшиг, гийгүүлэгч эгшиг гийгүүлэгч гийгүүлэгч эгшиг ийм бүрэлдэхүүнтэй байна гэж үздэг. Жишээлбэл:

|            |        |        |            |
|------------|--------|--------|------------|
| томьёолол: | монгол | кирилл | өдгөөгийн  |
|            | бичиг  | бичиг  | төв аялгуу |
| ГЭГЭ       | bele   | бэл    | belte      |
| ЭГГЭ       | alta   | алт    | alla       |
| ЭГЭ        | eke    | эх     | exe        |
| ГЭГГЭ      | berke  | бэрх   | berxe      |

Дурдсан жишээнээс үзэхэд монгол бичиг, монгол хэлний төв аягуу өөрөөр хэлбэл ярианы хэлэнд хоёр үеэр бүтсэн язгуур байдаг, үүнийг манай кирилл үсэгт хоёр гийгүүлэгч нэг дор эгшиггүй бичин нэг үе болгож байна.

Хоёр үеэр бүтсэн язгуурыг ажиглахад, бүтэц нь үг бүтээх янз бүр бүтээвэр ялган салгаж гол төлөв болдог байна. Цас гэсэн үгийг өнгөцхөн харахад задрахгүй үг мэт бөгөөд гагцүү бусад үгтэй харшуулан үзэж ца- гэсэн мөхсөн язгуур, с-бүтээвэр хоёроор бүтсэн үг байна гэж сая мэдэж болохын адил, хоёр үеэр бүтсэн язгуурыг сайтар шинжлэн үзэхэд, урьд задардаг үг байгаад, хожим түүхэн хөгжилдөө язгуур нь мөхсөний улмаас задрах чадвараа алдсан бололтой байх нь олонтоо тохиолдоно. Жишээлбэл, бэлэн, бэлдэх, бэлтгэл, бэлэг гэх мэт үгэнд ордог бэл(э) гэсэн язгуур байна. Бэлэг гэдгийн -г нь гагцхүү үйл үгэнд залгадаг дагавар учир бэл(э) гэсэн нь үйл үгийн үндэс мөн байна. Хэрэв тийм бол -л(э) нь нэр үгээс үйл үг үүсгэх бүтээвэр, бэ- нь мөхсөн язгуур байж болох юм. Алтан гэсэн үгийн -та, -н гэсэн нь үг бүтээх бүтээвэр, ал-гэдэг нь язгуур байж болох бөгөөд хурц улаан, гоё улаан юм гэсэн үг байж болох юм. Эртний бичигт ал тамга гэж сайхан улаан будгаар дарсан тамгыг нэрлэдэг байжээ.

Хэрэв хоёр үеэр бүтсэн үндсийг монгол хэлний үүднээс задлаж болохгүй бол, монголтой төрөл хэлний хэрэглэгдэхүүнтэй харшуулан үзэхэд уул язгуурын бүтэц тодорхой болох нь нилээд буй. Жишээлбэл:

өгүүл-(ᠶᠡᠭᠦᠭᠦᠯᠡ) гэдийн өгүү- юу гэсэн үг вэ? гэдгийг монгол хэлний үүднээс тайлбарлаж болохгүй. Гэтэл энэ туйл хэлний өг ойлго гэсэн үгийн нөхцөл үйлийн хэлбэр өгү гэдгээ: үүссэн байна.<sup>1</sup>

Дээр дурдсан зүйлээс үзэхэд, орчин цагийн монгол хэлний язгуурыг мөхсөн, амьд гэж хоёр анги болгон үзэж болох нь аяндаа илэрхий байна. Мөхсөн язгуур нь биеэ даасан утгагүй, дангаагаа үг болж чадахгүй байна. Жишээлбэл: я-с(ᠶᠡᠰᠡ), ца-с(ᠴᠢᠰᠡ) л-ай(ᠯᠠᠢ). Амьд язгуур нь биеэ даасан бодит утгатай нэр, үгийн нэрлэхийн тийн ялгал, үйл үгийн захирах хүсэх төлбийн хоёрдугаар биеийн хэлбэртэй адил бөгөөд түүний хойноос үг хувилгах дагавар залгаж болдгийн хувьд үгийн үндэс болдог байна.

### Үндэс

Монгол хэлэнд биеэ даасан тухайн утгатай бөгөөд янз бүрийн бүтээвэр залгаж, цаашид хувилгаж болох, үгийн тийм хэсгийг үндэс гэдэг. Үндэс нь ганц язгуур, язгуур дагавар хоёр, язгуур хэд хэдэн дагавраас тус тус бүтэж болно. Залгаж байгаа дагавар бүхэнд, түүний өмнөх (биеэ даасан утгатай) хэсэг нь үндэс болдог. Жишээ: нь малын гэдэгт мал нь үндэс, малжих гэдгийн малж нь үндэс, малжихын гэдэгт малжих нь үндэс болно.

Язгуураар бүтсэн үндсийг нэгдүгээр үндэс, язгуур дагавар хоёроор бүтсэн үндсийг хоёрдугаар үндэс, язгуур хоёр дагавраар бүтсэний нь гуравдугаар үндэс, язгуур гурван дагавраар бүтсэний нь дөрөвдүгээр үндэс гэх мэтчилэн нэрлэдэг. Гэхдээ, нэгдүгээр үндэс, язгуур хоёрыг нэг адил зүйл гэж үзэж хэрэвч болохгүй. Зөвхөн амьд язгуур л нэгдүгээр үндэс болохоос биш, мөхсөн язгуур бол үндэс болж чадахгүй. Учир нь мөхсөн язгуур бол биеэ даасан утгагүйн дээр, үг хувилгах дагавар залгаж болохгүй. Жишээлбэл: цас гэдгийн ца- язгуур нь өдгөө үгийн үндэс бус, гагцхүү-с дагавартайгаа нийлж нэг үндэс болно.

Нэг, хоёр, гурав, дөрөвдүгээр үндсийг жишээгээр үзүүлбэл:

амь- да- ра- л  
I II III IV

<sup>1</sup> Өгүүл- гэсэн үгийг үг гэсэн үгээс гаргалтай мэт зарим хүмүүсийн тайлбарладаг нь шинжлэх ухааны ямар ч үндэсгүй, хоосон санаанаас авч бичсэн „хар тайлбар“ гэдэг зүйл болохыг далимд нь тэмдэглэе. Хэлний шинжлэлд хар тайлбар гэдэг нэр бол, хар ухаанаараа, шинжлэх ухааны үндэсгүй, гагцхүү өөрийнхөө ухаарсан ойлголт о үгтэй холбож тайлбарлагчийг нэрлэдэг юм. Ийм хар тайлбарын жишээ болгон эрэгтэй, эмэгтэй гэдийг эрхтэй, ээмэгтэй гэж дуудан эрх, ээмэг гэсэн үгийн хамтрахын тийн ялгал мэт ухдагийг дурдаж болно. Эрэгтэй эмэгтэй гэдэг нь эр, эм гэсэн үгэнд-гтэй дагавар тус тус залгаж үүсчээ.

### Дагавар

Үгийн язгуураас бусад бүтээвэр бүгдийг залгавар гэдэг. Залгавар нь, дотроо эзэлж байгаа байраараа, гүйцэтгэж байгаа үүргээрээ янз янз байдаг. Язгуурын өмнө орох залгаврыг утгвар гэх бөгөөд, иймс нь монгол хэлэнд байхгүй.<sup>1</sup> Язгуурын хойноос орох залгаврыг дагавар гэдэг. Жишээлбэл: ном-ч, хар-уул, сур-г(а)-ууль (gu+li), зөв-лө-х, зөв-лө-л гэх мэт.

Дагавар нь дангаараа биеэ даасан утгагүй бөгөөд үгийн үндсэнд шинэ утга оруулах буюу үгийн хоорондын харьцааг илтгэх үүрэгтэй байна.

Үнэхээр -чин гэсэн дагаврыг аваад үзвэл тодорхой бодит утгагүй ажилчин, тариачин, тэмээчин, усчин гэх мэтчилэнгээр үгийн үндсэнд залахад арай тодорхой болж байна. Дурдсан үгсийг нарийвчлан ажиглахад, тус бүрийнхээ үгсийн сангийн янз янз утгаас гадна, ямар нэг ажил хөдөлмөр эрхлэдэг хүнийг заасан нэг ерөнхий утгатай байна. Энэ ерөнхий, хийсвэр утга нь -чин гэсэн дагавраар илэрч байна. Үүгээр үзэхэд дагавар нь огт утгагүй зүйл биш байна.

Дагаврын зүйлийг үгийн дотор гүйцэтгэж байгаа үүргий нь хувьд үг бүтээх, үг хувилгах дагавар гэж хоёр хуваагаад, товчлохын үүднээс үг бүтээх дагаврыг зүгээр дагавар хэмээгээд, үг хувилгах дагаврыг зүүвэр гэдэг.

Үг бүтээх дагаврын жишээ болгон хэдэн үг авч үзье.

|           |           |           |
|-----------|-----------|-----------|
| хад-уур   | хам-уур   | хан-уур   |
| мал-чин   | ан-чин    | сал-чин   |
| хара-втар | шара-втар | хөхө-втөр |

Эдгээр үгийг ажиглан харахад хар үсгээр бичсэн хоёрдугаар бүтээвэр нь үүргийн хувьд нэгдүгээрээсээ өөр байна. Хэрэв бүтэн үг (хадуур гэх мэтчилэн) тухайн бодисыг нэрлэсэн юм уу, эсэхүл (малчин гэх мэтчилэн) тухайн хүнийг заасан, эсэхүл (харавтар гэх мэтчилэн) тухайн шинж тэмдгийг илтгэсэн байвал, язгуурын дараах бүтээвэр нь тухайн бодис, хүн, шинж тэмдэг тус бүр нэг нэгэн төрөл буюу анги бодис, хүн, шинж тэмдэгт багтаж байгааг заана.-уур дагаврыг харахад, ийм дагавартай үгсээр нэрлэсэн юмс зэвсэг багажийн ангид, -чин дагаврыг үзэхэд, ийм дагавартай үгсээр нэрлэсэн хүмүүс цөм ямар нэг ажил хэрэг эрхлэгсдийн ангид, -втар дагавартай үгсийн зааж буй шинж тэмдэг нь сулавтар, дутуу дулимгийн ангид багтах нь үзэхүйц илхэн байна.

Ийнхүү үг бүтээх дагавар хэмээгч нь язгуурын дараа орж бодис, шинж тэмдэг, үйлийн анги зэргийг илтгэх залгавар аж.

Үг бүтээх дагавар нь, хэл бүтээдэг хэрэглэгдэхүүний нэг хэсэг нь бөгөөд нэг үгээс нөгөө үг үүсгэхэд хэрэглэгддэг байна.

Үг бүтээхэд үндэс болж өгч байгаа язгуур буюу үндсийг үг бүтээх язгуур буюу үндэс гэдэг. Жишээлбэл: малчин гэдэг үгийн мал гэсэн нь, үг бүтээх язгуур болно.

Үг бүтээх язгуур буюу үндсэнд дагавар залгаж бүтсэн үгийг үүсмэл үг гэдэг. Жишээлбэл: гал гэсэн язгуураас бүтсэн галла, цас гэдэг үндэснээс бүтсэн цаст гэдэг нь үүсмэл үг болно.

Үг бүтээх язгуур буюу үндэснээс үүсмэл үгийг буй болгож байгаа зэвсгий нь үг бүтээх дагавар гэдэг.

<sup>1</sup> Жишээлбэл, орос хэлэнд утгвар байдаг. Приятель гэхэд приятэдэг нь утгвар, -тель гэдэг нь дагавар, -я гэдэг нь язгуур болно.

Ийнхүү, үг бүтээх дагавар нь язгуурын дараа орж, хэлэнд бэлэн байгаа язгуур, үндэснээс шилэ, үүсмэл үг бүтээн гаргах дагавар аж.

### Үүсмэл, эс үүсмэл үг

Үгийн дотор үг бүтээх дагавар байгаа эсэхээс бүх үгийг үүсмэл, эс үүсмэл гэж хоёр хувиана.

Үүсмэл үг гэдэг нь дотроо үг бүтээх дагавартай үгийг хэлнэ. Бүрэлдэхүүн дотор нь үг бүтээх дагавар байхгүй үгийг эс үүсмэл үг гэнэ.

Үүсмэл үг бүхэн нь, бодис, үйл, шинж чанарыг нэрлэхийн хамт эдгээр нь бодит байдлын бусад үзэгдэлтэй холбогдолтой болохыг заана. Жишээлбэл: ХУРУУВЧ гэхэд хуруутай холбогдолтой, тухайлбал хуруунд угладаг юм, НҮДҮҮР гэхэд нүдэх үйлтэй холбогдолтой, тухайлбал нүдэх үйлийг гүйцэтгэдэг зэвсгийг зааж байна.

Үүсмэл бус үг нь юмыг нэрлэхдээ тухайн үзэгдэл бодит байдлын бусад үзэгдэлтэй чухам ямар холбогдолтой болохыг илтгэдэггүй байна.

Үг нь үүсмэл үг үү, эс үүсмэл үг үү гэдгийг ялгах төвөгтэй асуудал юм. Үүнийг нэг тийш болгохын тул тухайн үгийн жинхэнэ нэрлэж байгаа хэсгийг нь, эсэхүл тухайн үзэгдлийг бусад үзэгдлээс ялгаж байгаа шинж тэмдгийг нь, эсэхүл үүсмэл үгийн зааж байгаа үзэгдлийн холбогдолтой бодисыг тодорхойлох хэрэгтэй. Хэрэв ингэж тодорхойлж болохгүй бол эс үүсмэл үг байна. Жишээлбэл: МАЛЖ гэсэн үг, МАЛ-Ж гэж задраад, энэ үгийн нэрлэж байгаа зүйл, бодит байдлын ямар үзэгдэлтэй холбогдолтой нь илэрхий байна. СУРАГ, ЗОРИГ гэсэн үгсийг ажиглавал, СУР(а)-г, зори-г гэж задрах бөгөөд сурах, зорих үйлтэй холбогдолтой нь илхэн. Гэтэл ШҮЛЭГ гэсэн үгийг аваад үзвэл шүл(э)-г гэж задрахгүй, шүлэг гэсэн үгийн илтгэж байгаа зүйлийн холбогдолтой тийм бодис монгол хэлэнд олдохгүй. ШҮЛ- гэсэн хэсэг нь бодит байдлын ямар нэг үзэгдлийг нэрлээгүй байна. Учир нь ШҮЛЭГ гэсэн үг, самгардийн шлока гэсэн үг байна.

Ийнхүү, үүсмэл үг гэхдээ ямар үгээс үүссэн нь тодорхой бөгөөд үүсгэсэн үг нь байваас, сая үүсмэл үг гэж ярьж болох аж.

Хэлэнд ганцхан үгэнд тохиолдоод дахин гардаггүй дагавар гэж бараг байдаггүй. Аливаа дагавар ядахдаа хоёр үгэнд байна. Жишээлбэл: -вх дагавар идэвх, усавх гэсэн үгэнд байна. Ийм нэг янзын үг бүтээх дагавартай үгсийг хэлзүйн анги гэдэг.

### Зүүвэр

Мал-ч, мал-ж, мал-ыг, мал-саг

Мал-ын, мал-д, мал-ла, мал-аас гэсэн хоёр хэсэг үгийг авч үзье. Нэгдүгээр хэсгийн залгавар, үг бүтээх дагавар болох нь бидний дээр өгүүлснээс тодорхой байна. Хоёрдугаар хэсгийнх нь үг бүтээх дагавар биш байна. Үг бүтээх дагавар биш юм бол ямар үүргийг гүйцэтгэж байгаа вэ? үүнийг мэдэхийн тулд „Малын хашаа барья“, „Малд өвс хэрэгтэй“, „Малыг сайн арчлах хэрэгтэй“ гэх мэт хэдэн өгүүлбэр зохиогоод үзвэл, эдгээр бүтээвэр, өгүүлбэр доторхи үгсийн хоорондын янз бүрийн холбоо харьцааг зааж байгаа нь тодорхо харагдана. Малын хашаа гэхэд -ын дагавар нь юунд хашаа хамаатай, юуны хашаа болохыг, малд өвс хэрэгтэй гэхэд чухам

юунд өвс хэрэгтэйг, мал, өвс хоёрын хоорондын холбоог -Д дагавар малыг гэхэд -ыг дагавар нь үйлэнд өртөж байгаа юмыг өөрөөр хэлбэл мал арчлах хоёрын харьцааг тус тус зааж байна. Ийнхүү, хоёрдугаар мөрт, байгаа дагавар нь цөм нэгэн адил үүрэгтэй бөгөөд тухайн үгийн бусад үгтэй ямар харьцаа холбоотой байгааг илрүүлж байна. Ингээд үг хувилгах дагавар буюу зүүвэр<sup>1</sup> гэдэг нь тухайн үгийн бусад үг, өгүүлбэртэй ямар харьцаатай болохыг заах дагавар аж.

### Тэг бүтээвэр

Тухайн хэлзүйн утгыг илтгэсэн атлаа, ямар нэг буюу хэсэг авиагаар илрээгүй тийм бүтээврийг тэг бүтээвэр гэдэг.

Хэдэн үг жишээ болгон аваад үзье,

Ард, ард-ын, арда-д, ардыг-, ард-аас гэсэн хэдэн үгийг аваад үзэхэд бүх шууд бус тийн ялгал нь, үндэс дагавар хоёроос бүтсэн бөгөөд -ын, -д-, -ыг-, ААС гэсэн зүүвэр бол харьяалах, өгөх орших, заах, гарахын тийн ялгалын утгын гадаад шинж тэмдэг нь болж байна. Үүнд -ын гэдгээр харьяалахын тийн ялгалын утгыг, -д гэдгээр өгөх оршихын тийн ялгалын утгыг илтгэж байна.

Гэтэл ард гэсэн үг ямар ч бүтээвэргүй цэвэр үндэс үү? Өнгөцхөн харахад ард хэмээх үг нь цэвэр үндэс шиг санагдаж болно. Хэрэв тийм бол тийн ялгалгүй үг байх нь. Гэтэл тийм бус бөгөөд энд нэрлэхийн тийн ялгал байгаа нь хялбархан мэдэгдэх юм. Яаж нэрлэхийн тийн ялгалын утга илрэв? Үндсээр илрэв үү? гэвэл, үгүй байна. Хэрэв тийм байсан бол харьяалахын тийн ялгал гэгч нь нэрлэхийн тийн ялгал-ын гэж хэлж болох байсан. Үүнээс үзэхэд цэвэр үндэс, нэрлэхийн тийн ялгал хоёр, өөр өөр зүйл болох нь тодорхой. Тэгвэл бид юугаар нь нэрлэхийн тийн ялгалд байгаа үг гэж мэдэв? Энд авиагаар, материалаг бүрхэвчээр илрээгүй боловч, нэрлэхийн тийн ялгалын утгыг илтгэж байгаа биегүй нэг юм байна.

Ийнхүү материалаг бүрхэвчгүй, авиагаар илрээгүй мөртлөө хэлзүйн утгыг илтэгдэг тийм бүтээврийг тэг бүтээвэр гэдэг. Тэг бүтээвэр гэж ярихдаа бид түүнийг материалаг бүтээвэртэй зэрэгцүүлэн үзэж байж, сая ойлгож байна. Иймэрхүү үзэгдэл ганц хэлэнд байдаг бус юм.

Багш, сурагчдын дэврийг шалгах аар хураан аваад үзэхэд, бүгд нэргүй байвал, хэн хэний дэвтэр болохыг мэдэж чадахгүй. Гэтэл нэг л дэвтэр нэргүй, бусад нь цөм нэртэй байвал, сурагчдын бүртгэлд нэрсийг тулган үзээд, нэргүй дэвтэр хэний болохыг олж болно. Үүнд огт тэмдэггүй байгаа нь, харин ялгах тэмдэг болж өглөө.

Хэдэн айлын янз янз имтэй хонин дотор нэг айлын хэдэн имгүй хонь байна гэж бодъё. Тэгвэл, тэр сүрэг хонийг айл айлын нь имээр

<sup>1</sup> Хэлний шинжлэлд зүүврийг бүтцийн нь хувьд хоёр хувиаж үздэг. Монгол, турк, солонгос, япон зэрэг хэлэнд үгийн язгуур, зүүвэр хоёр хоорондоо холбоогүй бөгөөд, язгуур нь дангаараа зүүвэргүй хэрэглэгддэг. Жишээлбэл: Малын гэдгийн мал нь биеэ дааж дангаараа хэрэглэгдэнэ. Ийм язгууртайгаа холбоогүй зүүврийг бас наалдвар гэдэг. Гэтэл орос хэлний ДНО „ёроол“ гэсэн үгийн зүүвэр О-г хасвал ДН- гэсэн язгуур үлдэх бөгөөд энэ язгуур нь зүүвэртэйгээ маш нягт холбоотой учир дангаараа биеэ дааж хэрэглэгдэхгүй. Тийм, язгууртай нягт холбоотой зүүврийг сүүл буюу нугалбар гэдэг.

ялгахад, имгүй хэсэг хонийг нь, тэдний хонь гээд, нэг хэсэг холбох бус уу. Үүнд, имгүй хонь төрөл бүрийн имтэй хонины адил нэг холбоо болж байгаа явдал бол материаллаг тэмдэггүй нь чухам шинж тэмдэг болж байгаа хэрэг аж.

### Дагаврын үүсэл

Дагавар бол түүхэн ай юм. Иймээс үүсч, хөгжин хувирч, мөхөж байдаг тавилантай.

Өргөн хэрэглэгддэг зарим үг, урт удаан хөгжлийн үр дүнд дагавар болон хувирдаг. Өдгөөгийн дагавар бүхэн урьд биеэ даасан үг байсан. Жишээлээд монгол хэлний оршихын тийн ялгалын -Д зүүврийг авч үзье.

Оршихын тийн ялгалын зүүвэр нь монгол бичгийн хэлэнд 𐰃 𐰄 𐰅 𐰆 𐰇, монголтой төрөл түрк хэлэнд-(да-дэ),(ат-тэ), хамниган хэлэнд -ду, -ту, манж хэлэнд-Дэ гэсэн хэлбэртэй байдаг. Гэтэл солонгос хэлэнд ийм оршихын тийн ялгал байдаггүй бөгөөд, „орших газар, байр“ гэсэн утгатай тай (дай) гэсэн нэр үг байдаг байна. Энэ үг бол өргөн хэрэглэгддэг бөгөөд бусад үгтэй нийлж, нийлмэл үг бүтээдэг ажээ.

Жишээлбэл:

йэ, энэ “+ дай -йэдай „энд“  
чэ „тэр“+ дай -чэдай „тэнд“,

Энэхүү тай (дай) гэсэн үг нь монгол, түрк, манж, хамниган хэлэнд тийн ялгалын зүүвэр болон хувираад, солонгос хэлэнд чингэж хувиралгүй хэвээр үлджээ. Ийм учраас солонгос хэлэнд энэхүү оршихын тийн ялгал байхгүй байна.

Монгол хэлний ихэнх дагавар хөгжлийнхөө замд бүрэн биеллээ олсон байна. Гагцхүү зарим нэг нь биеэ даасан үгээс дагавар болох хэлзүйн хөгжлийн шатыг туулан гарч амжаагүй байна. Өдөр гэсэн үг маргаа-дар, нөгөө-дөр, цаад-дар, өнөө-дөр, урж-дар, уржиг-дар гэсэн үгэнд өөрийнхөө авианзүйн хэлбэрийг, үгсийн сангийн зүйн биеэ даасан байдлын хамт алдаж,-дар,-дэр,-дөр гэсэн хэдэн хувилбар бүхий дагаврын чанартай болжээ. Мөн тэрчлэн зэрэгцэх нөхцөл үйлийн дараа орсон очих гэсэн үгээс үйл үгийн бүрмөсөн үйлдэх байдлын дагавар -ч үүсчээ. Явж+очих -явчих

Ингэж хэлний хөгжих замд зарим дагавар үүсэн гарч, зарим нь хэлэнд хэрэглэгдэхээ болин мөхөж, заримын нь хэрэглэгдэх хүрээ явцууран шинэ үг үүсгэхээ болиод, зөвхөн урьд үүссэн хуучин үгэнд үлдээд байхад, зарим нь шинэ шинэ үг үүсгэн хэрэглэгдэх хүрээ нь улам өргөссөөр байна.

Эртний монгол хэлний үйл үгийн өнгөрсөн цагийн эм хүйсийг илтгэх зүүвэр -би хэрэглэгдэхээ бүрмөсөн больжээ. Ийнхүү орчин үеийн хэлэнд бүрмөсөн хэрэглэгдэхээ больсон дагаврыг мөхсөн дагавар гэдэг.

Эртний монгол хэлэнд нэр үгийн эм хүйсийг илтгэж байсан -жин дагавар гунжин, дөнжин гэх төдийхөн үгэнд үлджээ. Иймсийг бүтээцгүй дагавар гэнэ.

Нэр үгээс үйл үг үүсгэх -ж дагавар машинажих, цахилгаанжих гэх зэргийн шинэ үгийг үүсгэжээ. Энэ мэтчилэн тухайн хэлний үгийн санг шинэ үг үүсгэн баяжуулж байдаг дагаврыг бүтээцтэй дагавар гэдэг.

## Нийлмэл дагавар

Дагаврын зүйлийг бүтцийн нь хувьд бас энгийн, нийлмэл гэж хоёр хувиадаг. Нийлмэл дагавар хэмээгч, утга а хоёр буюу түүнээс дээш тооны дагавраас бүтсэн боловч нэг утгыг агуулан, нэг дагавар мэт хэрэглэгдэх болсныг хэлдэг. Жишээлээд -вчил дагаврыг аваад үзье. Энэ дагавар бол нэр үгээс нэр үг үүсгэх -вч, нэр үгээс үйл үг үүсгэх -л дагавар хоёроос бүтжээ. Энэ нь хуруувчил гэсэн үгнээс тодорхой байна. Тэр ч байтугай хуруувчил гэсэн үгийг ажиглан харахад -вчил гэдэг нь нэг нийлмэл биш, хуруу гэсэн үг дээр-вчил гэсэн дагавар залгаагүй, хуруувч гэсэн үг дээр -л дагавар залгаж үүссэн мэт санагдана. Гэтэл ихэвчил гэсэн үгийг аваад үзвэл ихэвч + -л гэж үүссэн байж таарахгүй. Учир нь ихэвч гэсэн үг монгол хэлэнд байхгүй. Ингэхлээр их + вчил гэж үүссэн нь илэрхий. Үүнээс -вчил гэсэн нийлмэл дагавар байна гэж үзэх нь зүйтэй байна. Тэхдээ ийм нийлмэл дагавар болсон нь хожмын хэрэг. Анхандаа -вч дагавартай нэр үг дээр -л дагавар залгаж үйл үг үүсгэж байсан нь, сүүлд -вч, -л хоёр дагавар хоорондоо нягт холбоотой нийлмэл дагавар болоод, үүний улмаас -вч дагаврыг дангаар нь залгадаггүй нэр үгээс ч үйл үг үүсгэх болжээ.

Бид ийнхүү хэлний барилгын хэрэглэгдэхүүн болох үгийг хэлзүй ёсоор хэрэглэхийн тул түүний бүтцийг мэдэх чухал гэсэнчлэн монгол үгийн бүтэцтэй товч танилцлаа.

Монгол үгийн бүтэц нарийн бөгөөд тодорхой. Үг нь язгуураар эхлэж, түүний дараа янз бүрийн үг бүтээх дагавар орож, үгийн тусгай утга буюу үгсийн сангийн утгыг илтгэсэн үндсийг үүсгэх бөгөөд түүний дараа хэлзүйн хийсвэр утга илтгэх зүүвэр орох аж.

Монгол үгийн бүтцийг бүдүүвчлэн үзүүлбэл:

язгуур + дагавар + зүүвэр: мал + -ч + л + -ын + -(х) аа.

Хэвлэлтэнд 1960 оны 5 дугаар  
сарын 16-ны өдөр. Цаасны хэмжээ  
60X92.1/16. Хэвлэлийн хуудас 1  
Хэвлэсэн тоо 2000.  
~~Б-01483~~ ~~Зах. № 33~~

Эрдэм шинжилгээний хэвлэх  
үйлдвэр. Лениний гудамж. 5